



**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

**УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ**

14251 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,

II хороо, Чингисийн өргөн чөлөө 11

Утас: 62263168, Факс: (976-11) 31-23-15

И-мэйл: info@mrttd.gov.mn, https://www.mrttd.gov.mn

2016.10.11 № 38-07-002/06

Тээврийн хэрэгслийн дугаар  
үйлдвэрлэх үйл ажиллагаанд  
хяналт шалгалт хийсэн тухай

Зам, тээврийн сайдын 2016 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу Тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх ажил эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд “Тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг” MNS 4410:2002 стандартын хэрэгжилт, тус яамтай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийн байдалд хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах зорилгоор холбогдох албан тушаалтнуудыг байлцуулан ЗТЯ-ны ХШҮДАГ-ын ЗТХХ-ийн ахлах мэргэжилтэн Т.Мөнх-Оргил, ахлах мэргэжилтэн, улсын байцаагч Д.Энх-Амгалан, МХЕГ-ын ДБХГ-ын улсын ахлах байцаагч П.Тамир, “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын ТХБГ-ын дарга Б.Энхцэцэг нарын бүрэлдэхүүнтэй 2016 оны 04 дүгээр сарын 22-ны өдрөөс 5 дугаар сарын 02-ны өдрийг дуустал хугацаанд хийлээ.

**Тодорхойлох нь:**

Хяналт шалгалтаар тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 31 аж ахуйн нэгж байгууллагаас одоогоор үйл ажиллагаа явуулж байгаа 14 аж ахуйн нэгж, байгууллагын 17 үйлдвэр, тэдгээрийн 2 удирдах албан тушаалтан, 32 ажилтан хамрагдлаа.

Тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх үйл ажиллагааг МХЕГ-ын даргын баталсан 5.34 кодтой “Тээврийн хэрэгслийг дугаар үйлдвэрлэх үйл ажиллагааг шалгах” хяналтын хуудсаар шалгахад 15 ААНБ-ын 16 үйлдвэрээс 8 / “РЭС” ХХК, “Жи Эл Ти” ХХК-ийн 1,2, “Ихэр авто 2 дугаар салбар” ХХК, “Лайт лотус” ХХК, “Альфа солбицол” ХХК, “Аталар” ХХК, “Өнгөт тэнгэр” ХХК/ нь дунд эрсдэлтэй, 6/ “Женеральроль” ХХК, “Эхлэл ургац” ХХК, “Эйспартнерс” ХХК, “Тэнүүн интерьер дизайн” ХХК, “Ихэр авто 1” ХХК, “Ти энд Си” ХХК/ бага эрсдэлтэй, 2/ “Төгрөг дугаар” ХХК, “Ихэр авто 2” ХХК/ их эрсдэлтэй дүгнэгдсэн.

“БЖНК” ХХК, “Гүн гомбо” ХХК, “Ньюпрезидент” ХХК, “Бэлус трейд” ХХК, “Крейзисдиид” ХХК, “Би Би Эм Зэт” ХХК, “Өгөлэд хайрхан” ХХК, “Монголиан лейдинг констракшн” ХХК, “Их сүх эрдэнэ” ХХК, “Майнингпартнерс” ХХК, “Криэтивхэндс” ХХК, “Их бялхам” ХХК, “Өтгөн төгөл” ХХК, “Юникплайтс” ХХК зэрэг 14 аж ахуйн нэгж, байгууллагууд үйл ажиллагаа явуулах тоног төхөөрөмж, үйлдвэрлэлийн байргүй, “Тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх ажил эрхлэх” тусгай зөвшөөрөл авахад өгсөн хаяг, байршил дээр байхгүй байлаа.

**Дүгнэх нь:**

“БЖНК” ХХК, “Гүн гомбо” ХХК, “Ньюпрезидент” ХХК, “Бэлус трейд” ХХК, “Крейзисдиид” ХХК, “Би Би Эм Зэт” ХХК, “Өгөлэд хайрхан” ХХК, “Монголиан лейдинг констракшн” ХХК, “Их сүх эрдэнэ” ХХК, “Майнингпартнерс” ХХК, “Криэтивхэндс” ХХК, “Их бялхам” ХХК, “Өтгөн төгөл” ХХК, “Юникплейтс” ХХК зэрэг 14 аж ахуйн нэгж, байгууллагууд нь үйлдвэрлэл явуулах тоног төхөөрөмж, байргүй, үйл ажиллагаа явуулахгүй байгаа нь Автотээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5.3-т заасан тухайн ажил үйлчилгээнд мөрдүүлэхээр эрх бүхий байгууллагаас баталсан стандарт, дүрэм, журмаар тогтоосон нөхцөл шаардлагыг хангахгүй байна гэж дүгнэлээ.

**ДҮГНЭЛТ ГАРГАСАН:**

ХШУДАГ-ЫН ЗТХХ-ИЙН АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН, УЛСЫН БАЙЦААГЧ



Д.ЭНХ-АМГАЛАН